



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/24

Хажуу шинэ-Ус

Бүх нийтийн цэвэрлэгээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12, 9.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Угтаал сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хаврын бүх нийтийн цэвэрлэгээг 2024 оны 03 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. 2024 оны 03 сарын 27-ны өдөр албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх бүр орчны 50 метр газраа цэвэрлэх, 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр албан байгууллага аж ахуйн нэгж, иргэд нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг сумын төвийн багийн Засаг дарга (Л.Батбаатар)-т үүрэг болгосугай.

3. Их цэвэрлэгээнээс гарсан үүсмэл хог хаягдлыг цаг хугацаанд нь тээвэрлэх ажлыг сумын төвийн багийн засаг даргатай хамтран зохион байгуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Даваасүрэн)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Цэрэнчунт)-д даалгасугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож бүгд хамрагдахад анхаарч ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч (Э.Ванчиндорж), цагдаа (Б.Наранбаатар) нарт даалгасугай.

ДАРГА  ТАРИУНАА



482401024